



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Одот Тэнгэр Оршихуй ӨЭМТ-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal.g@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetseg.ya@audit.gov.mn

Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн захирал О.Бурмаа
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-15 № 728
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ОДОТ ТЭНГЭР
ОРШИХУЙ ӨЭМТ-ИЙН ДАРГА
Э.САРНАЙ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Одот тэнгэр оршихуй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, 50,187 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Одот тэнгэр оршихуй ӨЭМТ нь анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын болон 3 төрөлт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 872.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/406 тоот тушаалаар 312/2025 дугаартай батламжаар 2 жилийн хугацаатай "Магадлан итгэмжлэгдсэн" эрүүл мэндийн байгууллага болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Одот тэнгэр оршихуй ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 20 байхаар баталж, тайлант онд 20 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Одот тэнгэр оршихуй ӨЭМТ-ийн 2025 оны гуравласан гэрээний биелэлт 84.3 хувь, ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлт 90.1 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	504,075.92	1,175,733.68
1.1.02	Дансны авлага		416,763.34
1.1.04	Бусад авлага	10,544,032.95	12,285,900.10
1.1.06	Бараа материал	37,712,742.49	27,646,372.68
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	48,760,851.36	41,524,769.80
1.2.01	Үндсэн хөрөнгө	95,795,234.60	98,747,504.18
1.2.02	Биет бус хөрөнгө	1,650,000.00	1,650,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	97,445,234.60	100,397,504.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	146,206,085.96	141,922,273.98
2.1.1.1	Дансны өглөг	16,266,893.58	6,719,121.21
2.1.1.2	Цалингийн өглөг	2,399,500.00	
2.1.1.3	Татварын өр	12,035,312.75	16,567,448.43
2.1.1.4	НДШ-ийн өглөг	23,325,158.45	12,230,682.99
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	54,026,864.78	35,517,252.63
2.2	Өр төлбөрийн нийт дүн	54,026,864.78	35,517,252.63
2.3.01	Өмч: - төрийн	-	-
2.3.02	-хувийн	100,000.00	100,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	92,079,221.18	106,305,021.35
2.3.11	Эздийн өмчийн дүн	92,179,221.18	106,405,021.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	146,206,085.96	141,922,273.98

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Нийт орлогын дүн	749,592,389.93	879,148,369.28
1.1	Санхүүжилтийн орлого	749,592,389.93	866,584,291.35
1.2	Бусад орлого		3,660,728.00
1.3	Туслах үйл ажиллагааны орлого		8,903,349.93
02	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
04	Нийт ашиг (алдагдал)	749,592,389.93	879,148,369.28
05	Хүүний орлого	57,855.58	143,229.79
09	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	685,125,439.14	865,051,475.92
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	64,524,806.37	14,240,123.15
19	Орлогын татварын зардал	5,785.56	14,322.98
20	Татварын дараах ашиг (алдагдал)	64,519,020.81	14,225,800.17
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,519,020.81	14,225,800.17
24	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,519,020.81	14,225,800.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	725,022,235.72	879,761,436.72
1.1.1	Татаас, санхүүжилтийн орлого	724,964,380.14	870,714,857.00
1.1.2	Туслах үйл ажиллагааны орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	57,855.58	9,046,579.72
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	725,022,235.72	879,761,436.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	674,065,653.56	854,063,078.96
1.2.1	Ажилчдад төлсөн	406,034,850.94	628,587,454.04
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	94,474,754.51	79,534,626.84
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	99,781,672.77	33,039,350.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,305,000.00	26,450,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		10,900,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	39,753,289.81	49,206,107.42
1.2.9	Бусад мөнгөн зарлага	16,716,085.53	26,345,540.66
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	674,065,653.56	854,063,078.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	50,956,582.16	25,698,357.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,627,760.00	25,026,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,627,760.00	25,026,700.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,627,760.00)	(25,026,700.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаасаас хүлээн авсан		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	328,822.16	671,657.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	175,253.76	504,075.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	504,075.92	1,175,733.68

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	5,056,722.37	5,156,722.37
02	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	22,503,478.00	22,503,478.00
03	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	27,560,200.37	27,660,200.37
04	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
08	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	64,519,020.81	64,519,020.81
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	92,079,221.18	92,179,221.18
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	92,079,221.18	92,179,221.18
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	14,225,800.17	14,225,800.17
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	106,305,021.35	106,405,021.35

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 145,431.6 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс 145,431.6 мянган төгрөгний 4 алдааг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Санхүү байдлын тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 207.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг;
- Санхүү байдлын тайланд ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэл 106.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг;
- Мөнгөн гүйлгээний тайланд 145,104.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын зардлыг зөрүүтэй тайлагнасныг;
- Орлогын дэлгэрэнгүй тайланд 14.3 мянган төгрөгийн хүүгийн орлогын татварын зардлыг зардлын ангилалын зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулсан.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана. 5.1.4 “үнэн, зөв байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” , 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүү байдлын тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 207.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	207.2			1	207.2	1	207.2				
2	Санхүү байдлын тайланд ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэл 106.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.	1	106.0			1	106.0	1	106.0				
3	Мөнгөн гүйлгээний тайланд 145,104.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын зардлыг зөрүүтэй тайлагнасан.	1	145,104.1			1	145,104.1	1	145,104.1				
4	Орлогын дэлгэрэнгүй тайланд 14.3 мянган төгрөгийн хүүгийн орлогын татварын зардлыг зардлын ангилалын зөрүүтэй тайлагнасан.	1	14.3			1	14.3	1	14.3				
	Дүн	4	145,431.6			4	145,431.6	4	145,431.6				

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Шилэн дансны нэгдсэн системд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх 3 дугаар улирлын мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.	1	632,699.7	-	-	1	632,699.7	-	-
	Дүн	1	632,699.7	-	-	1	632,699.7	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 188/15625538

Улаанбаатар хот

НТАГ-2026/011/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Одот тэнгэр оршихуй өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр арван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх гуравдугаар улирлын 632,699,700.0 (зургаан зуун гучин хоёр сая зургаан зуун ерэн есөн мянга долоон зуу) төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6.9-д "Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр ... төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр ..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Одот тэнгэр оршихуй Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Э.Сарнай), нягтлан бодогч (Р.Оюунжаргал) нарт даалгав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ

О.БУРМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090842

